

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны I улирлын тойм мэдээ

МАНАЙ ҮНДСЭН ЗОРИЛГО

Дэлхийд тэргүүлэх, аюулгүй, тогтвортой зэсийн бизнесийг хамтдаа цогцлоож, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах

МАНАЙ АЛСЫН ХАРАА

Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ



Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!

Ил уурхай, Оюу толгой


Манай ажлын үзүүлэлт, 2026 оны I улирлын тойм мэдээ



ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ




ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ



Зорилт (91.7 тонн,
нэгдүгээр улиралд)

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ



Зорилт (113.1
мянган унц,
нэгдүгээр
улиралд)

- Оны эхний улиралд гүний уурхайн зэс болон алтны үйлдвэрлэл шинэ дээд амжилт тогтоолоо. Мөн ил уурхайн алтны үйлдвэрлэл өндөр байсан нь энэ онд үйлдвэрлэлийн төлөвлөгөөндөө хүрэх суурийг тавилаа.
- Панел 2-ын огтлох түвшний тэсэлгээ, хүдэр олборлох юүлүүр болон хүдэр татах цэгүүдийн бүтээн байгуулалт төлөвлөгөөт хуваариас гүйцэтгэл өндөртэй байсан нь гүний уурхайн олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэлээ.
- Баяжуулах үйлдвэрийн болон гүний уурхайн хүдэр тээвэрлэх системийн төлөвлөгөөт засварыг аюулгүй, үйлдвэрлэлд сөрөг нөлөөлөлгүй амжилттай хийж гүйцэтгэлээ.



ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2026, I УЛИРАЛ)

2.2

ИХ НАЯД ТӨГРӨГИЙГ

ТАТВАР ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨРТ
ТӨЛЖЭЭ.

Татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ* зэрэг бусад төлбөрт 16.6 их наяд төгрөг** 2010 оноос хойш төлсөн.

* “Оюу толгой” ХХК НӨАТ-ын буцаан олголт авдаггүй.

** Энэ дүнд Олон улсын арбитра хэлэлцэгдэж буй 2.9 их наяд төгрөгийн татварын маргааны дүн багтсан болно.



Тайлант хугацаанд Улаанбаатар–Оюу толгой чиглэлд 80,523 зорчигч зорчсон бөгөөд энэ нь дотоодын нислэгийн нийт урсгалын 84.2%-ийг бүрдүүлж байна. * Энэ нь орон нутгийн агаарын тээврийн компаниудын 10 зорчигч тутмын 8 нь Оюу толгойн ажилтан гэсэн үг юм.

* Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2026, I УЛИРАЛ)

4

ИХ НАЯД ТӨГРӨГ

2026 оны нэгдүгээр улиралд дотоодын эдийн засагт 4 их наяд төгрөгийн бодит урсгалыг бий болгожээ.

(2010-2026, I УЛИРАЛ)

59.8

ИХ НАЯД ТӨГРӨГ

Үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, бусад хамтын ажиллагаа, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд 2010 оноос хойш 59.8 их наяд төгрөг зарцууллаа.

71%

Аж ахуй нэгж, бусад байгууллагад төлсөн төлбөр (НӨАТ-тай)

22%

Улс, орон нутгийн төсөвт шууд төлсөн төлбөрүүд

7%

Цалин

ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ

(2026, I УЛИРАЛ)

1.5

ИХ НАЯД ТӨГРӨГ

2010 оноос хойш дотоодын худалдан авалтад 40.5 их наяд төгрөг зарцуулсан бөгөөд үүнээс 1.5 их наяд төгрөгийг 2026 оны нэгдүгээр улиралд зарцуулсан байна. Тайлант хугацаанд нийт худалдан авалтын зардлын 85 хувийг дотоодын ханган нийлүүлэгчдэд зарцуулсан бөгөөд нийт 738 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 536 нь дотоодын ханган нийлүүлэгч байв.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ

(2026, I УЛИРАЛ)

303.8

ТЭРБУМ ТӨГРӨГ

2010 оноос хойш Өмнөговь аймагт бүртгэлтэй ханган нийлүүлэгчдээс нийт 6.4 их наяд төгрөгийн бараа, үйлчилгээ худалдан авсан байна. Тайлант хугацаанд Өмнөговь аймгийн 99 ханган нийлүүлэгчдээс 303.8 тэрбум төгрөгийн бараа, үйлчилгээний худалдан авалт хийсэн байна.

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН ДАВТАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Зорилт
*0.27-аас бага байлгах

Гүйцэтгэл
0.34

2026 оны нэгдүгээр улиралд гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.34 ноогдож байна. Жилийн зорилтот түвшинд хүрэхийн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн хэрэгжүүлж байна.

МОНГОЛ АЖИЛЧДЫН ХУВЬ

Хөрөнгө оруулалтын
гэрээгээр хүлээсэн үүрэг 90%

97.8%

ЭМЭГТЭЙ АЖИЛТАН

24.4%

БОЛОВСРОЛ, ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

“Оюу толгой” компани ирээдүйн чадварлаг уурхайчид, инженерүүд, салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэхэд хувь нэмрээ тууштай оруулсаар байна.



УЛСЫН ХЭМЖЭЭНД

2010 оноос хойш 2,323 сурагч/оюутан Залуусын хөгжлийн хөтөлбөр, Дотоодын болон гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдлаа.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД

2016 оноос хойш 855 оюутан Говийн оюу оюутны тэтгэлэг, Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хамрагдлаа.



КАРЬЕР ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

2013 оноос хойш 1,617 сурагч/оюутан Шинэ төгсөгчийн хөтөлбөр, Дадлагын болон Дадлагажигч хөтөлбөр, Ажил, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдлаа.

Манай ажлын үзүүлэлт, 2026 оны I улирлын тойм мэдээ



Ханбогд хотхон,
Ханбогд сум




ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2026, I УЛИРАЛ)




“Оюу толгой” компани Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон холбогдох гэрээнүүдийн дагуу ус ашигласны төлбөрийг бүрэн төлж ирсэн бөгөөд 2013 оноос хойш ус ашигласны төлбөрт нийт **226 тэрбум** төгрөг төлсөн.



2026 оны нэгдүгээр улиралд ус дахин ашиглалтын зорилт 80 хувь байсан бөгөөд зорилтоо давуулан биелүүлж, дунджаар 86.3 хувьд хүргэв.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ (2026, I УЛИРАЛ)


(НЭГ ТОНН ХҮДЭР БОЛОВСРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН УСНЫ ХЭМЖЭЭ, ШОО МЕТР, САРААР)



Нэг тонн хүдэр боловсруулахдаа 2026 оны нэгдүгээр улиралд нөхөн сэлбэлтээр 0.45м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

ОЮУ ТОЛГОЙ ҮЙЛДВЭРИЙН УС АШИГЛАЛТ

(ЛИТР/СЕКУНД, САРААР)



Оюу толгой үйлдвэр Засгийн газраас тогтоож өгсөн хязгаараас бага ус хэрэглэж байна.



Ус нөөцлөх байгууламж, Оюу толгойн уурхай
Энэхүү ус нөөцлөх байгууламж нь ууршилтаас хамгаалсан геомембран бүрхүүлтэй бөгөөд энэ нь усыг ариг гамтай хэрэглэх чухал технологи юм.

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА

ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

(2026, I УЛИРАЛ)



2011 оноос хойш Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд нийт **486.6 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийжээ.

Боловсрол	899 сая төгрөг
Байгаль орчин	31.5 сая төгрөг
Түүх соёл	20 сая төгрөг
Эрүүл мэнд, сайн сайхан байдал	312.6 сая төгрөг
Дэд бүтэц	341.6 сая төгрөг
Орон нутгийн бизнесийн хөгжил	703.1 сая төгрөг
Спорт	1.5 тэрбум төгрөг

Манай ажлын үзүүлэлт
2026 оны I улирлын тойм мэдээ



Спорт амралтын цогцолбор төсөл, Ханбогд сум
Ханбогдын хөгжлийн хурдасгуур Оюу толгой сангаас 26.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж байна.



ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

100
САЯ МОД
Өвлүүлэн үлдээе

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДАРААХ АЖЛУУДЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭВ:

- 2025 онд Өмнөговь аймгийн Манлай, Баян-Овоо сумдад байгуулсан мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг цаашид хариуцан ажиллахаар шалгарсан байгууллагад хүлээлгэж өгөх ажлыг эхлүүллээ.
- Сэлэнгэ аймгийн нутагт хариуцлагагүй уул уурхайн нөлөөгөөр эвдэрч, орхигдсон 400 га талбайг нөхөн сэргээх төслийн төлөвлөгөөг эцэслэн боловсруулах зорилгоор оролцогч талууд болох Ойн газар, Хараа-Ерөө голын сав газрын захиргаа, Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газар, сумдын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчидтай хамтын санал, шийдлүүдийг хэлэлцлээ



 Буйлс цэцэглэх цагаар, Ханбогд сум